



## НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГА ХУДАЛДААНД УРЬЖ БАЙНА

Монголбанкны Захирлуудын зөвлөлийн хурлын шийдвэр, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А-185 дугаар тушаалаар Өвөрхангай, Баянхонгор аймаг дахь Монголбанкны салбарын хуучин барилгыг нээлттэй дуудлага худалдаагаар худалдахаар шийдвэрлэв.

### Барилгын танилцуулга:

Барилгын нэр: Өвөрхангай аймаг дахь Монголбанкны салбарын барилга  
Байршил: Өвөрхангай аймаг, Арвайхээр сум, 5-р баг, Рэнчинпэлжээгийн гудамж  
Эзэмшил газрын хэмжээ: 776 м.кв  
Ашиглалтанд орсон он: 1971  
Барилгын хэмжээ : 14.2 х 33,6 х 7,8 м /хэсэгчлэн зарагдсан  
Давхрын тоо: 2, барилгын тал хэсэгт зорьтой  
Талбайн нийт хэмжээ: 703 м.кв  
Хийц бүтээц: бутобетон шугаман суурьтай, тоосгон ханатай, модон хучилттай, шувуун нуруутай, төмөр дээвэртэй  
Инженерийн төвлөрсөн шугамд холбогдсон, 1 машины гараажтай

Барилгын нэр: Баянхонгор аймаг дахь Монголбанкны салбарын барилга  
Байршил: Баянхонгор аймаг, Баянхонгор сум  
Эзэмшил газрын хэмжээ: 1101 м.кв  
Ашиглалтанд орсон он: 1966  
Барилгын хэмжээ : 10.5 х 30,8 х 6,9 м  
Давхрын тоо: 1, зорьгүй  
Талбайн нийт хэмжээ: 329 м.кв  
Хийц бүтээц: бутобетон шугаман суурьтай, тоосгон ханатай, модон хучилттай, шувуун нуруутай, төмөр дээвэртэй  
Инженерийн төвлөрсөн шугамд холбогдсон, 2 машины гараажтай

Дуудлага худалдаа болох хугацаа	2015 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 10:00 цагт
Дуудлага худалдаа болох газар	Монголбанкны “Г” байр, Үндэсний цахим гүйлгээний төвийн уулзалтын өрөө
Санал болгох доод үнэ	Өвөрхангай аймаг дахь Монголбанкны салбарын хуучин барилга 150,530,302.23 (нэг зуун тавин сая таван зуун гучин мянга гурван зуун хоёр төгрөг хорин гурван мөнгө) төгрөг
	Баянхонгор аймаг дахь Монголбанкны салбарын хуучин барилга 36,801,139.71 (гучин зургаан сая найман зуун нэг мянга нэг зуун гучин есөн

	төгрөг далан нэгэн мөнгө) төгрөг
Дуудлагын худалдаанд тавих дэнчингийн хэмжээ	Өвөрхангай аймаг дахь Монголбанкны салбарын хуучин барилгын доод үнийн 20 хувь буюу 30,106,060.00 (гучин сая нэг зуун зургаан мянга жаран) төгрөг
	Баянхонгор аймаг дахь Монголбанкны салбарын хуучин барилгын доод үнийн 20 хувь буюу 7,360,228.00 (долоон сая гурван зуун жаран мянга хоёр зуун хорин найман) төгрөг
Худалдах, худалдан авах гэрээний ерөнхий нөхцөл	Худалдан авагч нь дуудлага худалдаагаар худалдан авсан эд хөрөнгийн үнийг 14 хоногийн дотор төлнө.
Дэнчинг байршуулах данс	Хүлээн авагч байгууллага: Монголбанк дансны дугаар: 4101000022 дансны нэр: бусад

### Дуудлагын худалдаанд хүсэлт ирүүлэх

1. Дуудлагын худалдаанд оролцох хүсэлтийг 2015 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 10:00 цаг хүртэл Монголбанкны “А” байрны 1 дүгээр давхрын 2 тоот өрөөнд хүлээн авна. **Хугацаа хоцорсон хүсэлтийг хүлээн авах боломжгүйг анхаарна уу.**

2. Дуудлагын худалдаанд оролцох хүсэлт нь зөв, цэвэр бөглөсөн худалдаанд оролцох хүсэлтийн маягт, дэнчин төлснийг нотлох баримт, иргэний үнэмлэх (аж ахуйн нэгжийн хувьд улсын бүртгэлийн гэрчилгээ)-ний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар зэрэг баримтаас бүрдэнэ.

### Худалдах үл хөдлөх хөрөнгийн мэдээлэл авах

Худалдах барилгын талаарх мэдээлэл, дуудлагын худалдааны журам, худалдаанд оролцох хүсэлтийн маягтыг Монголбанкны [www.mongolbank.mn](http://www.mongolbank.mn) вэб хуудас эсвэл Монголбанкны “А” байрны 2 дугаар давхрын ресепшинээс ирж авна уу. Дуудлага худалдаанд оролцохыг сонирхсон этгээд барилгатай танилцахыг хүсвэл Өвөрхангай аймаг дахь Монголбанкны хэлтэс, Баянхонгор аймаг дахь Монголбанкны салбар дээр очиж уулзана уу.

Лавлах утас: 310633, 329295, Өвөрхангай аймаг дахь Монголбанкны хэлтэс 70322337,  
Баянхонгор аймаг дахь Монголбанкны салбар 70442156

**МОНГОЛБАНК**